

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2022/93/ НА-СА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Дархан-Уул аймаг
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**
Утас: **7037-3089**
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn
Ахлах аудитор: **С.Батцэцэг**
Утас: **7037-3089**
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn
Аудитор: **Т.Эрдэнэтуяа**
Утас: **9511-2689**
Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2022.02.25 № 205

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

У.Ш.МӨНХБАЯР/

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	50.2	49.8
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	419.3	419.5
	Нийт хөрөнгийн дүн	469.6	469.4
	Нийт өр төлбөрийн дүн	0.0	0.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	469.6	469.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	469.6	469.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	434.1	316.9
	Үйл ажиллагааны зардлын дүн	287.9	316.2
	Үйл ажиллагааны үр дүн	146.2	0.7
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	146.2	0.7
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	323.4	469.6
	Тайлант оны үр дүн	146.2	-183.6
	Эцсийн үлдэгдэл	469.6	469.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	287.2	303.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	287.2	296.6
	Үйл ажиллагааны ЦМГ	0.0	6.4
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	0.0	-6.4
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0	0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	302.7	302.3
	Урсгал зардал	302.7	295.9
	Хөрөнгийн зардал	0.0	6.4
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих	260.2	259.8
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	42.5	42.5

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Шарын гол сумын 2-р цэцэрлэг тайлант онд “Сургалтын идэвхитэй аргуудыг хэрэглэж хүүхэд бүрийн бие даан сурах үйлийг дэмжих, тэдгээрт тохирсон дасгал даалгаврын санг баяжуулан үр дүнтэй ашиглан “Чадварлаг баг” төсөл хөтөлбөрийн хүрээнд багшийн тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх, улмаар мэргэжлийн

бүлгийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.” гэсэн зорилгын хүрээнд дараахь зорилтын дэвшүүлж ажиллажээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Иргэний хандиваар 1170.0 мян.төгрөгийн камер, БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар эмчийн өрөөнд 734.0 мян.төгрөгийн тавилгатай боллоо

Дөрөв. Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 2 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 6 ажилчинд илүү цаг олгосон алдаа зөрчилд нөхөн төлүүлэх 1 акт тогтоов .

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								

		НИЙТ										
--	--	-------------	--	--	--	--	--	--	--	--	--	--

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	1	0.7					1	0,7		0.0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	1	0.7					1	0,7		0.0